

ХУДАЛДААНЫ БОДЛОГО

ДХБ-аас 2021 оны 03 сарын 17-19-ний өдрүүдэд Монгол улсын худалдааны бодлогыг үнэлэв. Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны Сайд Б.Батцэцэг худалдаа болон макро эдийн засгийн талаар өнгөрсөн 7 жилийн турш засгийн газраас баримталж байсан бодлого цаашдын зорилтыг танилцуулав. Уулзалтын үеэр 21 орны төлөөлөгчид санал бодлоо хэлж, мөн түүнчлэн өмнө нь бичиж хүлээлгэн өсгөн тайлантай холбоотойгоор ДХБ-ын гишүүн 16 орнуудаас 300 гаран асуулт ирүүлсэн. Монгол Улсын засгийн газраас эдийн засгаа төрөлжүүлэх, худалдааг хөнгөвчлөх, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр идэвхтэй бодлого баримталж нээлт-тэй, чөлөөт худалдааны бодлогыг хэрэгжүүлж олон талт худалдааны системийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгааг гишүүд онцоллоо. Гишүүн орнуудаас Засгийн газрын эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх болон худалдааны техникийн зохицуулалтыг шинэ түвшинд гаргахын тулд хөрөнгө оруулалтын орчин, худалдааны бодлого, зохицуулалтын ил тод байдлыг хангах хэрэгтэй байгааг тэмдэглэв.




Өнгөрсөн 20 жилд Монгол улсын авч хэрэгжүүлсэн худалдааны бодлогын арга хэмжээ түүний үр ашгийг судлах судалгааны ажлын гэрээг Монгол Улсын Их Сургуультай ТРАМ Төсөл гэрээлэв. Судалгаагаар үе үеийн Засгийн газрын улс төрийн тэргүүлэх чиглэлд үндэслэн түр зуурын арга хэмжээнүүдийг авдаг байжээ гэсэн гол дүгнэлт гарсан. Гол зөвлөмж нь ДХБ-ын үүргийг хэрэгжүүлэх, төрийн эрх бүхий байгууллагуудын хүлээх бүх үүрэг хариуцлагыг тодорхойлох Гадаад Худалдааны Бодлогын Хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэв. Мөн судалгаанаас үе үеийн Засгийн Газар дагаж мөрдөх Монголын худалдааны бодлогын зорилтуудыг агуулсан улс төрийн баримт бичиг (Бодлогын баримт бичиг)-тэй болохыг зөвлөлөө.

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ

2021 оны 01 сарын 19-20 өдрүүдэд ТРАМ төслөөс СХЗГ-т зориулсан хоёр цахим сургалтыг зохион байгуулав. Аудит болон менежментийн системийн баталгаажуулалт хийгч байгууллагуудад зориулсан Нэгдсэн менежментийн систем болон ISO 17021 Тохирлын Үнэлгээний Шаардлагуудын талаар олон улсын зөвлөхийн өгсөн тайлбаруудыг 80 гаруй оролцогчид сонирхон суралцав.

2021 оны 03 сарын 12нд Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороо 2020 онд хийсэн ажлын тайландаа үнэлэлт өгч 2021 оны арга хэмжээний төлөвлөгөөг батлав.

ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ



ЕХ дахь Монголын Худалдаа Мэдээллийг Дэмжих Төвийн (МХМДТ) цахим дэлгүүр www.mongolian-green-labels.eu 2021 оны 02 сард үйл ажиллагаагаа эхлүүлэв. Энэ нь 2020 оны 12 сард Берлинд нээгдсэн МХМДТ-н жижиглэнгийн

дэлгүүртэй зэрэгцэн ажиллах юм. Цахим дэлгүүр нь Монголын уул уурхайн бус бүтээгдэхүүнийг ЕХ-ны зах зээлд экспорт хийх илүү сайн гарц бий болгоход ТРАМ төслөөс дэмжиж буй бас нэгэн чухал үйл явдал юм. Ингэснээр 20 орчим ЖДҮ-ийн арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүнийг худалдаалж 150,000 еврогийн жижиглэнгийн борлуулалт хийсэн дэлгүүрийн маркетингийн сувгийг дэмжиж өгөх юм. Цахим дэлгүүр хос хэлний сонголттой ба, ЕХ-ны гишүүн орнууд руу хүргэлт хийх ажлыг дэлгүүрийн ажилтнууд хариуцаж байна. Герман загварын мэргэжилтнээр бүтээгдэхүүний сонголт, өрөлт хийхэд зөвлөгөө авах, цахим дэлгүүрийг програмчлах ажилд ТРАМ төслөөс дэмжлэг үзүүлэв. Германд Ковид-19-ын эсрэг хоригтой байгаа ч цахим дэлгүүртэй болсноор ЕХ-ы зах зээлд Монголын олон тансаг экспортын бүтээгдэхүүнийг үргэлжлүүлэн худалдаж борлуулах боломж бүрдэнэ.

Экспортын дэмжлэг авсан гурван кластер болон Монголын Хушны Самрын Кластер (ТРАМ төслийн кластерийн аргыг анх удаа амжилттай давтсан) хамтран Монголын Экспортын Кластерүүдэн Сүлжээ ТББ (МЭКС) 2021 оны 04 сарын 01 өдөр байгуулахад Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МУХАУТ) -д ТРАМ төслөөс зөвлөж ажиллалаа. "Экспортын кластер дэлхийн зах зээлд хүрэх гүүр" гэх уриа, лого бүхий энэхүү үндэсний хэмжээний кластерын байгууллага нь ТРАМ төсөл дууссаны дараа экспортыг хөгжүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэх тогтвортой бүтэц гэсэн хүлээлттэй байна. Энэ байгууллага үндэсний хэмжээний экспортын кластерийг сайжруулахад зөвлөх, жинхэнэ, идэвхтэй экспортын кластерүүдийн толгой байгууллага байж, шинээр байгуулагдаж буй экспортын кластерыг дэмжих, ЕХ-ны Кластерын Хамтын ажиллагааны Платформтой холбох, В2В бүтээгдэхүүний каталоги www.made-in-mongolia.net болон экспортын кластерийн цахим мэдээллийн төвийг ажиллуулах зэрэгт зөвлөж ажиллана. МЭКС нь цаашлаад Монгол Улсын засгийн газар, ЕХ болон бусад олон улсын түншүүдийн экспортын кластер хөгжүүлэх санаачилгыг хэрэгжүүлэх түнш болж ажиллах юм.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



НАРАНХҮҮГИЙН САРАНГУА

“Өнөөдрийн глобал эдийн засагт тулгамдаж буй сорилтуудын улмаас салбар бүрд, ялангуяа жижиг бизнесүүдийн хувьд нэгдэж кластер үүсгэх хэрэгцээ шаардлага тулгандаад байна. Ингэснээр дэлхийн стандартад нийцүүлж, ЕХ болон дэлхийн зах зээлд өөрсдийн үнэт бүтээгдэхүүний экспортоо нэмэгдүүлэх боломж тэдэнд нээгдэнэ.”

Ерөнхий мэдээлэл

Албан тушаал: Инару Биомедикал компанийн захирал, Монголын Гоо Сайхны Бүтээгдэхүүний Кластерийн удирдах зөвлөлийн гишүүн, Монголын Экспортын Кластерийн Сүлжээ ТББ-ийн дарга
Үндэс угсаа: Монгол
Ажилласан жил: 10+

Хатагтай Сарангуа 2016 онд Бизнесийн удирдлагын мастер зэргээ хамгаалсны дараа тэрээр байгалийн гаралтай арьс арчилгааны бүтээгдэхүүн үйлдвэрлэх Инару Биомедикал ХХК-ийг үүсгэн байгуулжээ. Тэрээр 2018 онд EU TRAM төслийн анхны экспортын кластерийн танилцуулгад уригдаж, удалгүй жижиг компаниуд хамтран ажиллах, хамтдаа өсөж хөгжих, гадаад зах зээлд хамтаараа гарахад нь туслах арга хэрэгсэл бол кластерийн менежментийн арга гэдэгт итгэлтэй болжээ. Хоёр жилийн өмнөөс гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хамтран амжилттай байгуулсан Монголын Гоо Сайхны Бүтээгдэхүүний Кластер ТББ-ийн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдов. Тэр үеэс кластерийн үйл ажиллагаагаа хөгжүүлэхэд идэвх чармайлттай оролцож, олон улсын зөвлөхүүдийн сургалт, зөвлөгөөг авч, гадаадын үзэсгэлэн худалдаанд хэрхэн бэлтгэж оролцох талаар суралцаар байна.

Одоо кластерийн гишүүд ЕХ-ны зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах зорилготойгоор ЕХ-ны бүртгэлд бүртгүүлэхээр бүтээгдэхүүнээ бэлтгэн завгүй ажиллаж байна. Улс орон болон бизнесийг хөгжүүлэхэд экспортын кластер нь чухал платформ болсон сайн туршлага дээрээ тулгуурлан МҮХАҮТ болон экспортын дөрвөн кластерийг багтаасан Монголын Экспортын Кластерийн Сүлжээ ТББ-ыг байгуулахад Наранхүүгийн Сарангуа идэвхийлэн оролцлоо. Цаашид илүү олон экспортын кластерүүд нэгдэх төлөвтэй байна. Энэхүү шинэ платформиор дамжуулан сүлжээний гишүүд хамтраад шинэ кластеруудыг бойжуулах, гишүүдээ сургах, тэдэнд зөвлөх, экспортын гарц нээх, ЕХ болон бусад улс орнуудын кластеруудтай хамтран ажиллаж, Монголдоо төдийгүй гадаад улс орнуудад экспортын кластеруудыг амжилттай хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах болно.

БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйл ажиллагаа 1: 2021 оны 01 сард баталсан хамгаалалтын арга хэмжээний журмыг Индонез, Киргизстан болон Чилийн жишээгээр жишээлж төрийн байгууллагын 30 гаруй төлөөлөлд танилцуулах хоёр удаагийн цахим арга хэмжээг зохион байгуулав (2021 оны 02 сарын 3-4)

Үйл ажиллагаа 2: Австрийн танхимын зөвлөхийн зүгээс МҮХАҮТ-ын цаашид баримтлах стратегийн талаар зөвлөсөн ажлын үр дүн нь МҮХАҮТ-ын удирдлага болон аймгийн салбаруудын ирээдүйн бүтэц, үйл ажиллагааны боломжит хувилбаруудыг авч үзэх боломжтой болсон бөгөөд удахгүй УИХ-аар Монголын танхимын тогтолцооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхэд тус нэмэр болно гэж хүлээж байна (2021 оны 02 сар)

Үйл ажиллагаа 3: ТРАМ төслийн дэмжлэгтэйгээр В2С болон В2В цахим платформыг Гадаад Харилцааны Яам болон МҮХАҮТ хамтран зохион байгуулсан цахим-худалдаагаар экспортыг хөгжүүлэх вебинарын үеэр танилцуулав (2021 оны 03 сарын 08)

Үйл ажиллагаа 4: МҮХАҮТ-ын ажилчид болон ЖДҮ-ийн төлөөлөлд зориулсан онцгой байдлын менежментийн сургалт (2021 оны 03 сарын 16)

Үйл ажиллагаа 5: Чөлөөт худалдааны хэлэлцээрийн цахим сургалт зохион байгуулав (2021 оны 03 сарын 22-31)

УДАХГҮЙ БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

- 2021 оны 04 сарын 1:** Төслийн удирдах хорооны 6-р хурал болж хүрсэн амжилт, төлөвлөж буй ажлуудтай танилцана
- 2021 оны 04 сарын 08:** Малын гаралтай түүхий эд нийлүүлэгч, худалдан авагчдын хооронд тохиролцох хэлэлцээ хийх арга хэмжээ болно
- 2021 оны 04 сар:** Худалдааны дүн шинжилгээний GTAP аргыг ашиглан мэдээллийн сан дээр ажиллах таван удаагийн сургалт зохион байгуулагдана.
- 2021 оны 04 сар:** ЖДҮ-ийн Газартай цаашид REX-ийн (бүртгэгдсэн экспортлогч) хэрэгжилтийн талаар ЕХ- Худалдаа эрхлэх газартай, өлөн гэдэсний экспортын асуудлаар МХЕГ болон ЕХ-Эрүүл мэнд эрхлэх газартай хамтран ажиллах боломжийн талаар цахимаар зөвлөлдөв.
- 2021 оны 04 сар:** Гадаад Худалдааны Хуулийн төсөл болон Гадаад Худалдааны Бодлогын Баримт Бичгийн эх бэлтгэх, мөн Дэмпингийн эсрэг болон саармагжуулах арга хэмжээний журмыг батлуулах Ажлын хэсгийн уулзалт
- 2021 оны 04 сар:** ЖДҮ-д зориулсан хямралын үеийн санхүүгийн удирдлага сургалт
- 2021 оны 05 сар:** Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах вакумжуулсан сургалт
- 2021 оны 05 сар:** Дорнод аймгийн хилийн цэг дээр хийх Худалдааг хөнгөвчлөх сургалт
- 2021 оны 05 сар:** Монгол Улсын Их Сургууль Гаалийн Ерөнхий Газар хамтран хийсэн эдийн засгийн коридорын судалгааны танилцуулга
- 2021 оны 05 сар:** МҮХАҮТ-ийн төлөөлөлд зориулсан нэмүү өртгийн хэлхээний шинжилгээ, хөгжлийн сургалт
- 2021 оны 05 сар:** В2В цахим каталогийг www.made-in-mongolia.net МЭКС хариуцан ажиллуулж эхлэх
- 2021 оны 05 сар:** Хүнсний бус бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн төслийг нийтэд сурталчлан таниулах
- 2021 оны 05-06 сар:** Гадаад худалдааны хууль болон худалдааг хөнгөвчлөх талаар нийтэд таниулах
- 2021 оны 06 сар:** МҮХАҮТ-аас Улаанбаатар хотод зохион байгуулах ЖДҮ-н экспортын кластерийн бүтээгдэхүүнээр оролцох
- 2021 оны 06 сар:** ЕХ-ы Худалдааны өдрүүд болон ТРАМ төслийн хаалтын хурал